ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/31/НА-СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Монгол Улсын Ерөнхий Аудиторын орлогч: Я.Самбууням
Утас: 329871 Цахим хаяг:sambuunyamya@audit.gov.mn
Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Энхжаргал
Утас: 261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn
Аудитор: Ж.Мөнхбилгүүн
Утас: 261628 Цахим хаяг: munkhbilguunj@audit.gov.mn

Улаанбаатар хот
2025 он

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд 14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 15
3.5.1 Төсвийн төлөвлөлт 15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл 16
3.5.3 Нэмэлт төсөв 16
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 17
3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт 17
4. АУДИТЫН ТАЙЛАН 19
4.1 Ерөнхий зүйл 19
4.2 Материаллаг байдал 19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 20
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд 20
4.5. Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн 21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 22
5.1 Төлбөрийн акт 22
5.2 Албан шаардлага 22
5.3 Зөвлөмж 23
6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ 24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2025.04.25 № 1606

танай _____-ны № _____-т

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИССЫН ДАРГА Д.СҮНЖИД ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар олон жилийн насжилттай авлагыг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг нийт 172.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хүний эрхийн Үндэсний Комисс нь тайлант онд Олон улсын байгууллагуудаас 250.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч 10 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар батлагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх, хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлж, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх 1223 гомдлыг шийдвэрлэж, 30 шаардлага, 56 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлж, хүний эрхийн боловсролыг дэмжих чиг үүргийн хүрээнд 458 удаагийн 828 цагийн сургалтыг зохион байгуулж 23,896 оролцогчийг хамруулсан байна.

Бусад асуудал

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд стратегийн 6 зорилго, 21 зорилтын хүрээнд 96 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 90.0 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\2025\0425 SNAG-25.Docx

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**321,011.9**	**246,859.8**
31	**МӨНГӨН ХӨРӨНГӨ**	**116,254.2**	**72,450.6**
31200	**Банканд байгаа бэлэн мөнгө**	**116,254.2**	**72,450.6**
31210	**Төгрөг**	**116,254.2**	**72,450.6**
31211	Төрийн сангийн харилцах	116,254.2	72,450.6
33	**АВЛАГА**	**107,614.1**	**80,320.7**
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,950.8	80,320.7
33300	Татаас, санхүүжилтийн авлага	20,181.3	-
33500	**Бусад авлага**	**85,482.0**	-
33510	Байгууллагаас авах авлага	85,482.0	-
35	**БАРАА МАТЕРИАЛ**	**97,143.6**	**94,088.5**
35100	**Түүхий эд материал**	**3,724.9**	**3,724.9**
35110	Тусгай зориулалттай материал	3,724.9	3,724.9
35400	**Хангамжийн материал**	**93,418.7**	**90,363.6**
35410	Бичиг хэргийн материал	5,473.7	10,579.4
35420	Аж ахуйн материал	1,091.0	1,448.9
35430	Сэлбэг хэрэгсэл	11,660.0	15,011.5
35440	Түлш, шатах тослох материал	-	560.1
35470	Бусад хангамжийн материал	75,194.0	62,763.7
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**2,027,362.6**	**3,387,804.4**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	**2,027,362.6**	**3,387,804.4**
39200	**Биет хөрөнгө**	**535,606.8**	**576,048.7**
39201	Барилга, байгууламж, орон сууц	15,512.4	15,512.4
39202	Хуримтлагдсан элэгдэл	(775.6)	(775.6)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	140,195.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(8,178.0)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	469,044.4	469,044.4
39206	Хуримтлагдсан элэгдэл	(101,893.4)	(179,211.1)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	226,718.9	226,718.9
39208	Хуримтлагдсан элэгдэл	(94,741.4)	(114,998.8)
39217	Ном	21,741.4	27,741.4
39300	**Биет бус хөрөнгө**	**1,491,755.8**	**2,811,755.8**
39303	Бусад биет бус хөрөнгө	**1,491,755.8**	**2,811,755.8**
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**2,348,374.4**	**3,634,664.2**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	**1,500.2**	**30,002.3**
41	**БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**	**1,500.2**	**30,002.3**
41300	**Өглөг**	**1,500.2**	**30,002.3**
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	13,002.3
41360	**Бусад өглөг**	**1,500.2**	**17,000.0**
41361	Байгууллагад төлөх өглөг	1,050.0	17,000.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	450.2	-
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**2,346,874.2**	**3,604,661.9**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	**2,346,874.2**	**3,604,661.9**
51100	Засгийн газрын оруулсан капитал	108,348.0	108,348.0
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	108,348.0	108,348.0
51200	**Хуримтлагдсан үр дүн**	**2,229,626.1**	**3,487,413.8**
51210	Өмнөх үеийн үр дүн	604,652.8	2,234,571.8
51220	Тайлант үеийн үр дүн	1,624,973.3	1,252,842.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,900.2	8,900.2
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**2,348,374.4**	**3,634,664.2**

01 ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**6,884,308.1**	**7,272,987.3**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**1,625,911.0**	**1,470,591.4**
120	**Нийтлэг татварын бус орлого**	**1,612,857.4**	**1,470,591.4**
120004	**Төсөв байгууллагын өөрийн орлого**	**1,514,857.4**	**1,460,195.0**
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,514,857.4	1,460,195.0
120009	Бусад орлого	98,000.0	10,396.4
122	**Тусламжийн орлого**	**13,053.7**	**-**
122002	Хандив тусламж /гадаад/	13,053.7	-
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**5,258,397.1**	**5,802,395.9**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**	**5,040,911.4**	**5,571,682.0**
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,040,911.4	5,571,682.0
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**217,485.7**	**230,713.9**
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	217,485.7	230,713.9
II	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**5,259,334.9**	**6,020,145.4**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**5,259,334.9**	**6,020,145.4**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**5,118,821.4**	**5,927,941.8**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**2,906,805.5**	**3,705,299.5**
210101	Үндсэн цалин	1,575,595.8	2,179,961.5
210102	Нэмэгдэл	661,399.0	858,690.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	277,215.0	351,120.0
210104	Урамшуулал	285,060.4	253,503.2
210105	Гэрээт ажлын хөлс	107,535.3	62,024.3
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**359,621.4**	**475,071.9**
210201	Тэтгэврийн даатгал	248,207.2	321,591.6
210202	Тэтгэмжийн даатгал	29,069.4	35,565.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,147.0	33,430.6
210204	Ажилгүйдлийн даатгал	5,193.5	16,262.6
210205	Эрүүл мэндийн даатгал	54,004.4	68,222.1
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**159,909.3**	**173,833.2**
210304	Байрны түрээс	159,909.3	173,833.2
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**417,203.9**	**390,323.7**
210401	Бичиг хэрэг	49,193.6	23,641.3
210402	Тээвэр, шатахуун	155,309.8	199,605.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,089.5	51,148.5
210404	Ном, хэвлэл	63,578.5	101,588.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	112,032.6	14,339.5
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**39,156.1**	**23,067.6**
210604	Урсгал засвар	39,156.1	23,067.6
2107	**Томилолт, зочны зардал**	**397,852.1**	**334,107.6**
210701	Гадаад албан томилолт	147,882.1	143,502.1
210702	Дотоод албан томилолт	249,970.0	190,605.5
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**322,665.7**	**334,529.6**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	303,562.1	270,470.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,716.0	57,885.5
210807	Газрын төлбөр	5,387.6	6,173.7
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**515,607.4**	**491,708.6**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,696.1	106,235.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	371,749.5	279,719.7
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	79,161.8	105,753.1

213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**140,513.5**	**92,203.6**
2131	**Засгийн газрын урсгал шилжүүлэг**	**27,600.0**	**30,122.9**
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	27,600.0	30,122.9
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**69,334.5**	**61,951.0**
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	69,334.5	61,951.0
2133	**Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг**	**43,578.9**	**129.7**
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,578.9	129.7
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)**	**1,624,973.3**	**1,252,842.0**
VI	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)**	**1,624,973.3**	**1,252,842.0**

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)**	**5,452,328.7**	**5,832,973.7**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**98,000.0**	**10,396.4**
120	**Нийтлэг татварын бус орлого**	**98,000.0**	**10,396.4**
120009	Бусад орлого	98,000.0	10,396.4
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**5,354,328.7**	**5,822,577.3**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**	**5,040,911.4**	**5,571,682.0**
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,040,911.4	5,571,682.0
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**313,417.3**	**250,895.3**
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	313,417.3	250,895.3
II	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗӨЭЛИЙН ДҮН**	**5,379,128.7**	**5,870,777.3**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**5,379,128.7**	**5,870,777.3**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**5,218,433.9**	**5,778,373.6**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**2,907,122.6**	**3,695,964.7**
210101	Үндсэн цалин	1,577,388.5	2,159,221.6
210102	Нэмэгдэл	661,399.0	888,628.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	276,146.2	350,921.1
210104	Урамшуулал	284,653.6	248,790.1
210105	Гэрээт ажлын хөлс	107,535.3	48,403.2
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**361,958.4**	**461,995.6**
210201	Тэтгэврийн даатгал	249,763.9	311,868.6
210202	Тэтгэмжийн даатгал	29,257.8	35,738.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,300.6	28,768.6
210204	Ажилгүйдлийн даатгал	5,193.5	16,897.6
210205	Эрүүл мэндийн даатгал	54,442.6	68,722.0
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**149,809.3**	**173,833.2**
210304	Байрны түрээс	149,809.3	173,833.2
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**337,500.4**	**392,310.9**
210401	Бичиг хэрэг	32,005.7	26,369.9
210402	Тээвэр, шатахуун	155,309.8	200,165.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,089.5	51,148.5
210404	Ном, хэвлэл	92,629.3	98,970.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,466.1	15,656.3
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**318,165.2**	**24,183.0**
210601	Багаж, техник, хэрэгсэл	242,873.6	-
210602	Тавилга	20,800.0	-
210604	Урсгал засвар	54,491.6	24,183.0
2107	**Томилолт, зочны зардал**	**397,852.1**	**334,107.6**
210701	Гадаад албан томилолт	145,643.6	142,738.7
210702	Дотоод албан томилолт	252,208.5	191,368.9
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**344,549.3**	**316,901.9**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	325,445.7	251,233.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,716.0	59,494.6
210807	Газрын төлбөр	5,387.6	6,173.7
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**401,476.6**	**379,076.8**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,896.1	91,831.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	356,580.5	287,245.2
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**160,694.8**	**92,403.6**
2131	**Засгийн газрын урсгал шилжүүлэг**	**27,600.0**	**30,122.9**
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-

213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	27,600.0	30,122.9
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**69,334.5**	**62,151.0**
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	69,334.5	62,151.0
2133	**Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг**	**63,760.3**	**129.7**
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,578.9	129.7
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20,181.3	-
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)**	**73,200.0**	**(37,803.6)**
V	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)**	**-**	**6,000.0**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**-**	**6,000.0**
2200	**Дотоод эх үүсвэрээр**	**-**	**6,000.0**
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	6,000.0
VI	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)**	**-**	**(6,000.0)**
VIII	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)**	**73,200.0**	**(43,803.6)**
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	43,054.2	116,254.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	116,254.2	72,450.6

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	**2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**108,348.0**	**8,900.2**	**604,652.8**	**721,900.9**
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	108,348.0	8,900.2	604,652.8	721,900.9
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,624,973.3	1,624,973.3
10	**2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**108,348.0**	**8,900.2**	**2,229,626.1**	**2,346,874.2**
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,945.8	4,945.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	108,348.0	8,900.2	2,234,571.8	2,351,820.0
17	Тайлант үеийн үр дүн	-	-	1,252,842.0	1,252,842.0
19	**2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**108,348.0**	**8,900.2**	**3,487,413.8**	**3,604,661.9**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗӨЭЛИЙН ДҮН**	**5,571,682,000.00**	**5,571,552,253.22**	**129,746.78**	**100.0**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**5,571,682,000.00**	**5,571,552,253.22**	**129,746.78**	**100.0**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**5,498,808,100.00**	**5,498,678,393.22**	**129,706.78**	**100.0**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**3,681,582,200.00**	**3,681,582,200.00**	**0.00**	**100.0**
210101	Үндсэн цалин	2,081,062,100.00	2,159,221,609.73	(78,159,509.73)	103.8
210102	Нэмэгдэл	1,028,699,500.00	888,628,607.08	140,070,892.92	86.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	372,780,000.00	350,921,132.31	21,858,867.69	94.1
210104	Урамшуулал	199,040,600.00	234,407,638.63	(35,367,038.63)	117.8
210105	Гэрээт ажлын хөлс	0	48,403,212.25	(48,403,212.25)	-
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**460,197,800.00**	**460,197,800.00**	**0.00**	**100.0**
210201	Тэтгэврийн даатгал	312,934,600.00	310,070,788.22	2,863,811.78	99.1
210202	Тэтгэмжийн даатгал	36,815,800.00	35,738,781.50	1,077,018.50	97.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,407,900.00	28,768,625.76	(10,360,725.76)	156.3
210204	Ажилгүйдлийн даатгал	18,407,900.00	16,897,558.47	1,510,341.53	91.8
210205	Эрүүл мэндийн даатгал	73,631,600.00	68,722,046.05	4,909,553.95	93.3
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**173,833,200.00**	**173,833,200.00**	**0.00**	**100.0**
210304	Байрны түрээс	173,833,200.00	173,833,200.00	0.00	100.0
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**366,531,000.00**	**366,529,340.00**	**1,660.00**	**100.0**
210401	Бичиг хэрэг	26,369,900.00	26,369,900.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	200,165,600.00	200,165,600.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	51,148,500.00	51,148,500.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	73,189,000.00	73,189,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,658,000.00	15,656,340.00	1,660.00	100.0
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**24,183,100.00**	**24,183,040.00**	**60.00**	**100.0**
210604	Урсгал засвар	24,183,100.00	24,183,040.00	60.00	100.0
2107	**Томилолт, зочны зардал**	**327,810,500.00**	**327,809,488.24**	**1,011.76**	**100.0**
210701	Гадаад албан томилолт	136,440,600.00	136,440,577.60	22.40	100.0
210702	Дотоод албан томилолт	191,369,900.00	191,368,910.64	989.36	100.0
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**151,239,000.00**	**151,229,365.00**	**9,635.00**	**100.0**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,561,400.00	85,561,049.00	351.00	100.0

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАГДМАЛ САНАЛ ДҮГНЭЛТ

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	59,503,800.00	59,494,579.00	9,221.00	100.0
210807	Газрын төлбөр	6,173,800.00	6,173,737.00	63.00	100.0
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**313,431,300.00**	**313,313,959.98**	**117,340.02**	**100.0**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,031,600.00	57,031,600.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	256,399,700.00	256,282,359.98	117,340.02	100.0
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**72,873,900.00**	**72,873,860.00**	**40.00**	**100.0**
2131	**Засгийн газрын урсгал шилжүүлэг**	**30,122,900.00**	**30,122,860.00**	**40.00**	**100.0**
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	30,122,900.00	30,122,860.00	40.00	100.0
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**42,751,000.00**	**42,751,000.00**	**0.00**	**100.0**
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,751,000.00	42,751,000.00	0.00	100.0
III	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**5,571,682,000.00**	**5,571,552,253.22**	**129,746.78**	**100.0**
31	**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**5,571,682,000.00**	**5,571,552,253.22**	**129,746.78**	**100.0**
310001	Улсын төсвөөс санхүүжих	5,571,682,000.00	5,571,552,253.22	129,746.78	100.0
65	**ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ**	**82**	**75**	**7**	**91.5**
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	68	59	9	86.8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	9	(2)	128.6
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**-**	**250,895,250.16**
21	**УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН**	**-**	**250,895,250.16**
210	**Бараа, үйлчилгээний зардал**	**-**	**250,895,250.16**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**-**	**14,382,500.00**
210104	Урамшуулал	-	14,382,500.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**-**	**1,797,812.00**
210201	Тэтгэврийн даатгал	-	1,797,812.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**-**	**31,781,540.80**
210404	Ном, хэвлэл	-	31,781,540.80
2107	**Томилолт, зочны зардал**	**-**	**6,298,078.81**
210701	Гадаад албан томилолт	-	6,298,078.81
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	165,672,506.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	165,672,506.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	30,962,811.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	30,962,811.56
II	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**-**	**250,895,250.16**
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**-**	**250,895,250.16**
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	250,895,250.16

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүний эрхийн Үндэсний Комисс нь эрхэм зорилгоо “Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хөхүүлэн дэмжих, хүний эрхийн соёлыг түгээх замаар хүн бүр эрх чөлөөтэй, эрх тэгш амьдрах, хөгжих нийгмийг цогцлоон бүтээхэд манлайлагч байх” гэж тодорхойлж, үйл ажиллагаандаа “Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, хүртээмжтэй байх, шударга, ил тод байх, хараат бус, бие даасан байх” зарчмыг баримталдаг байна.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд :

- Монгол Улсын хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийг хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэхэд хувь нэмрээ оруулах;
- Хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавих, бодитой, эерэг өөрчлөлт гаргах;
- Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд манлайлах;
- Хүний эрхийн соёл, үндэсний тогтолцоог бэхжүүлэх;
- Хүний эрхийн салбарт олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Хүний эрхийн үндэсний комиссын чадавхыг бэхжүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Комисс нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаж, Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх;
- Хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах;
- Хүний эрхийн талаарх олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах эсэх талаар санал хүргүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөл болон гэрээний хороодод мэдээлэл хүргүүлэх;
- Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах;
- Хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх;
- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;
- Хүний эрхийн асуудлаар төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
- Шаардлагатай асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээдээр судалгаа хийлгэх, тухайлсан асуудлаар мэргэшсэн шинжээч томилж, дүгнэлт гаргуулах;
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Төрийн байгууллага, албан тушаалтан хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх үүргийн хэрэгжилтэд энэ хууль болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавих;

Тайлант хугацаанд үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль - нэмэлт, өөрчлөлт;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль- нэмэлт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 3 удаагийн нэмэлт, өөрчлөлт;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 6 удаагийн нэмэлт, өөрчлөлт;
- Улсын Их Хурлын 2024 оны "Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 37 дугаар тогтоол;

Төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүний эрхийн үндэсний комиссын даргын 2020 оны А/19 дүгээр тушаалаар батлсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,286.3 сая төгрөгөөр буюу 54.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Мөнгөн хөрөнгө	116.3	72.5	(43.8)
Авлага	107.6	80.3	(27.3)
Бараа материал	97.1	94.1	(3.1)
Үндсэн хөрөнгө	2,027.4	3,387.8	1,360.4
Нийт хөрөнгө	**2,348.4**	**3,634.7**	**1,286.3**
Өр төлбөр	1.5	30.0	28.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,346.9	3,604.7	1,257.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**2,348.4**	**3,634.7**	**1,286.3**

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 43.8 сая төгрөгөөр буурсан нь Ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл буурснаас шалтгаалсан;
2. Авлагын дансны үлдэгдэл 27.3 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой авлага 78.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, татаас санхүүжилтийн авлага 20.2 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага 85.5 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалсан;
3. Бараа материалын данс өмнөх оноос 3.1 сая төгрөгөөр буурсан нь 174.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 177.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой;
4. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 1,360.4 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 236 дугаар тогтоолоор 140.2 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг балансаас баланс шилжүүлэн авсан, Нийслэлийн Засаг Даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/635 дугаар захирамж, ТӨБЗГ-ын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А1/188 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд байрлах 2499 м.кв талбай бүхий газрын эзэмших эрхийн гэрчилгээ авч бүртгэсэн, 6.0 сая төгрөгийн ном худалдан авснаас шалтгаалсан;
5. Өглөгийн дансны үлдэгдэлд ажил гүйцэтгэх гэрээ, Иргэний нийгмийн зөвлөл, Хүний эрхийн хамгаалагчийн хорооны гишүүдэд олгосон урамшууллаас үүссэн нийгмийн даатгалын шимтгэлийн үлдэгдэл 13.0 сая төгрөгөөр ажиллагсадтай холбоотой өглөг нэмэгдсэн, нэр бүхий хуулийн этгээдэд олгох төслийн санхүүжилт ороогүйгээс 15.5 сая төгрөгийн судалгааны ажлын гэрээний төлбөрийг олголгүй өглөг үүсгэж байгууллагад төлөх өглөг нэмэгдсэн;
6. Засгийн газрын хувь оролцоо данс нь тайлант үеийн үр дүн 1,625.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 14,704.3 сая төгрөгийг авч зарцуулахаар тооцон төлөвлөж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас хөрөнгийн зардлыг 8,000.0 сая, урсгал зардлыг 1,587.1 сая төгрөгөөр бууруулж, 5,117.2 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь хөрөнгийн зардалд төлөвлөсөн 8,000.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг төсвийг боловсруулаагүй, төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт ТГ-01/344, ТГ-01/456, ТГ-01/942, ТГ-01/1250, ТГ-01/1971 тоот албан бичгүүдээр төсөвт зардлын ангилал хооронд зохицуулалт хийлгэх хүсэлтийг хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 454.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд 5,571.7 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,571.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 5,571.6 сая төгрөгийг зарцуулж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.9 хувьтай, үндсэн үйл үйл ажиллагааны зардлын зарцуулаагүй үлдэгдэл 0.1 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
70409	Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих	**5,571.7**	**5,571.6**	0.1	99.9
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	**5,571.7**	**5,571.6**	0.1	99.9
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	5,441.8	5,441.7	0.1	99.9
80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэл хураамж	57.0	57.0	-	100.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	30.1	30.1	-	100.0
80918	Бусад	42.8	42.8	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Комисс нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 175.5 сая төгрөг, Австралийн Флиндерсийн их сургуулиас 12.8 сая төгрөг, Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 3.7 сая төгрөг, Икуал Райтс Траст байгууллагаас 14.8 сая төгрөг, Европын холбооноос 23.4 сая төгрөг, Швейцарын хөгжлийн агентлагаас 14.5 сая төгрөг, БНСУ-ын Үндэсний Цагдаагийн Их Сургууль, Ази Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн Үндэсний байгууллагуудын чуулган болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэгээс 6.3 сая төгрөг нийт 250.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг бүрдүүлсэн байна.

Үүнээс төсөл хөтөлбөр хэрэгжүүлж цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 16.2 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 31.8 сая төгрөг, томилолт, зочны зардалд 6.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 165.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 31.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.
Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2023 оны А/33 дугаар тушаалаар "Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г батлан даран бараа, ажил үйлчилгээг төлөвлөж, гүйцэтгэл 75 хувьтай байна. Үүнд:

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Бараа, ажил, үйлчилгээний нэр, төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Тендер шалгаруулалтын арга	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Хувь
1	Ном товхимол, сурталчилгааны материал хэвлүүлэх /23 дахь илтгэлийн эх бэлдэх, хэвлэх ажил/	Нэг эх үүсвэрээс худалдан авах арга	28.0	27.7	27.7	100.0
2	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын механизмын үнэлгээ	Харьцуулалтын арга	25.0	24.9	24.9	100.0
3	Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг англи хэлрүү орчуулах	Нээлттэй сонгон шалгаруулалтын арга	24.0	21.8	21.8	100.0
4	И-Монголия систем, иргэний бүртгэлийн цахимжилт дахь хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ судалгааны ажил	Харьцуулалтын арга	35.0	-	-	-
	Нийт дүн		112.0	74.4	74.4	75.0

Төлөвлөгөөнд туссан 1 ажлын сонгон шалгаруулалт амжилтгүй болж хэрэгжээгүй байна.

3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 7 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгажээ.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 1 хөтөлбөр, 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас биелэлт 90.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Үүнд:

Хүснэгт 3. Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

Д/д	Дэд дугаар	ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Хэмжих нэгж	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
7.1		70409 Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих						
	7.1.1	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлнэ.	7.1.1.1	Хүргүүлэх илтгэл	тоо	1	1	100.0
	7.1.2	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх	7.1.2.1	Гомдол шийдвэрлэлт	хувь	95.0	91.7	96.5

		гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.						
	7.1.3	Комиссын зөвлөмж, гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавина.	7.1.3.1	Зөвлөмж, шаардлагын хэрэгжилт	хувь	85.0	76	89.4
	7.1.4	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавина.	7.1.4.1	Хэрэгжилтэд хяналт тавих хууль тогтоомж	Тоо	4	4	100.0
	7.1.5	Хүний эрхийн боловсролыг дэмжиж, түгээн дэлгэрүүлнэ.	7.1.5.1	Сургалт	цаг	2,700	828	30.7
	7.1.6	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Улсын Их Хуралд хүргүүлнэ.	7.1.6.1	Тайлан	Тоо	1	1	100.0
	7.1.7	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах зөвлөмжийн биелэлтийг хангуулна.	7.1.7.1	Зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ	Тоо	1	1	100.0

Хөтөлбөрт тусгасан “Хүний эрхийн боловсролыг дэмжиж, түгээн дэлгэрүүлэх” зорилтын хүрээнд 2024 онд нийт 458 удаагийн 828 цагийн сургалтыг зохион байгуулж 23,896 оролцогчийг хамруулсан.

ТӨГИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн санхүүгийн үйл ажиллагаа нягтлан бодох бүртгэлийг сайжруулах, төсвийг зохистой удирдаж өр, авлага үүсгэхгүй байх, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ц.Энхжаргал, аудитор Ж.Мөнхбилгүүн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01/618 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,259.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 52.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагч нь албан хаагчдад хэмнэлтийн горимд шилжин ажиллах талаар үүрэг чиглэл өгч, бичиг хэрэг, ашиглалтын зардлыг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 32 горим хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Аудитаар 53.5 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Хүний эрхийн комиссын нэр бүхий аймаг дахь референтийн нэг өдрийн ажлыг сурвалжилсан контент бүтээлгэж цахим сайт болон олон нийтийн сүлжээгээр түгээх ажилд 1.3 сая төгрөгийг зарцуулсан;
2. Сургалт, уулзалт өдөрлөг зохион байгуулахтай холбоотой цайны зардалд нийт 52.2 сая төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1-д Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.4-т Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон хязгаарлалтыг мөрдөх, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах замаар зардлыг хэмнэж ажиллах зөвлөмж өгөв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд 18,034,375.00 /Арван найман сая гучин дөрвөн мянга гурван зуун далан таван/ төгрөгийн 3 гүйлгээ, тайлант оны төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг тус тус мэдээлээгүй, 3,714,059,112.00 /Гурван тэрбум долоон зуун арван дөрвөн сая тавин есөн мянга нэг зуун арван хоёр/ төгрөгийн 95 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь:
Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь тогтмол байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хүний эрхийн үндэсний комисс нь дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан бүтцийн нэгжгүй, дотоод аудиторгүй, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтангүй, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 14 дүгээр зүйлийн 14.2-т Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.10.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод

ТӨГӨЛИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж заасан тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:
Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төсвийн тухай хуулийн холбогдох заалттай, шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай тус тус нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5. Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 124.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 80.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 44.2 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн. Аудитын шийдвэрийн хэрэгжилт 95.0 хувийн биелэлттэй байна

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	80.5	2	80.5	100.0
Зөвлөмж	3	44.2	2	44.2	91.7
Нийт дүн	**5**	**124.7**	**4**	**124.7**	**95.0**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь тогтмол байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 172.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 3.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 163.4 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар илрүүлсэн 172.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 52.6 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: 1 Тайлант онд нэр бүхий 2 албан хаагчид эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 3.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1. "Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2. "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно: 1.2.1. төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид", 2 дугаар зүйлийн 2.3. "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана", Хүний эрхийн Үндэсний комиссын даргын 2023 оны А/17 дугаар тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.2.7 "Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээний биелэлт, ажлын үр дүнгийн үнэлгээг үндэслэн шагнаж урамшуулах, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, цалингийн шатлал нэмэгдүүлэх, зэрэг дэв олгох, ахиулах, бууруулах, ажлаас чөлөөлөх зэрэг арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон энэхүү журамд заасны дагуу шийдвэрлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:
Тушаал шийдвэргүй үр дүнгийн урамшуулал олгосон 3.3 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Дижитал технологийн эрин үед тулгамдсан хүний эрхийн асуудлыг Австрали улс хэрхэн зохицуулж, даван туулж байгаа туршлагыг танин мэдэх, хүний эрхийг хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах зорилготой "Цахим эринд хүний эрхэд суурилсан хөгжлийг дэмжих" хөтөлбөрийн санхүүжилтээс зориулалт зөрчин нэр бүхий их сургуулийн төгсөгчдийн холбооноос эмхэтгэн гаргасан "Профессорын эрдмийн дээжис" 120 боть номыг худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна." гэсэнтэй нийцэхгүй байна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Шийдвэрлэсэн нь:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Тайлант хугацаанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 59 ширхэг 12.8 сая төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийг актлах, үнийг шинэчлэн тогтоолгох асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 59 ширхэг 12.8 сая төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийг актлах, үнийг шинэчлэн тогтоолгох асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх

Илрүүлэлт 2: Албан томилолтын зардлаас анхан шатны бүрдэл дутуу 40.3 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх;", 13 дугаар зүйлийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 14 дүгээр зүйлийн 14.5-д "Аж ахуйн нэгж, байгууллагын аж ахуйн ажил, гүйлгээ нь аль улсын нутаг дэвсгэрт гарснаас үл хамааран холбогдох анхан шатны баримт, бүртгэлийн маягтыг энэ хуульд заасны дагуу бусад баримт, бүртгэлийн маягттай хамт хадгална.", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны бүрдэл дутуу баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд тусгахгүй байх

Илрүүлэлт 3: Төсвийг зохистой удирдаж ажиллаагүй 80.3 сая төгрөгийн авлага, 30.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 80.3 сая төгрөгийн авлага нь олон жилийн насжилттай авлагыг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх;", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, олон жилийн насжилттай авлагыг шийдвэрлүүлэх ажлын зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант хугацаанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 59 ширхэг 12.8 сая төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийг актлах, үнийг шинэчлэн тогтоолгох асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.	1	12.8					1	12.8
2	Албан томилолтын зардлаас анхан шатны бүрдэл дутуу 40.3 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	1	40.3					1	40.3
3	Дижитал технологийн эрин үед тулгамдсан хүний эрхийн асуудлыг Австрали улс хэрхэн зохицуулж, даван туулж байгаа туршлагыг танин мэдэх, хүний эрхийг хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах зорилготой "Цахим эринд хүний эрхэд суурилсан хөгжлийг дэмжих" хөтөлбөрийн санхүүжилтээс зориулалт зөрчин нэр бүхий их сургуулийн төгсөгчдийн холбооноос эмхэтгэн гаргасан "Профессорын эрдмийн дээжис" 120 боть номыг худалдан авсан байна.	1	6.0			1	6.0		
4	Төсвийг зохистой удирдаж ажиллаагүй 80.3 сая төгрөгийн авлага, 30.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 80.3 сая төгрөгийн авлага нь олон жилийн насжилттай авлагыг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй байна.	1	110.3					1	110.3
5	Тайлант онд нэр бүхий 2 албан хаагчид эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 3.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.	1	3.3	1	3.3				
	Нийт дүн	**5**	**172.7**	**1**	**3.3**	**1**	**6.0**	**3**	**163.4**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хүний эрхийн үндэсний комисс нь дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан бүтцийн нэгжгүй, дотоод аудиторгүй, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтангүй, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.	1	-					1	-
2	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд: 1. Хүний эрхийн комиссын нэр бүхий аймаг дахь референтийн нэг өдрийн ажлыг	1	53.5					1	53.5

	сурвалжилсан контент бүтээлгэж цахим сайт болон олон нийтийн сүлжээгээр түгээх ажилд 1.3 сая төгрөгийг; 2. Сургалт, уулзалт өдөрлөг зохион байгуулахтай холбоотой цайны зардалд нийт 52.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.								
3	Шилэн дансны мэдээллийн цахим санд нийт 6,816.9 сая төгрөгийн 131 гүйлгээ мэдээлэхээс 18.0 сая төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй, 3,714.1 сая төгрөгийн 95 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн тайлант оны төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.	1	18.0			1	18.0		
	НИЙЦЛИЙН ДҮН	**3**	**71.5**	**-**	**-**	**1**	**18.0**	**2**	**53.5**

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

2025 оны 04 сарын 25 өдөр Дугаар 223/АО111241 Улаанбаатар хот

СНАГ-2025/031-НА-СТА-ТЕ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нэр бүхий 2 албан хаагчид эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 3,265,400.00 /Гурван сая хоёр зуун жаран таван мянга дөрвөн зуун/ төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.", 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно: 1.2.1-д төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид", 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй үр дүнгийн урамшуулал олгосон 3,265,400.00 /Гурван сая хоёр зуун жаран таван мянга дөрвөн зуун/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАГДЖАВ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 25 өдөр Дугаар 1020/А0111241 Улаанбаатар хот

СНАГ-2025/031-НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүний эрхийн Үндэсний Комисс нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд 18,034,375.00 /Арван найман сая гучин дөрвөн мянга гурван зуун далан таван/ төгрөгийн 3 гүйлгээ, тайлант оны төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг тус тус мэдээлээгүй, 3,714,059,112.00 /Гурван тэрбум долоон зуун арван дөрвөн сая тавин есөн мянга нэг зуун арван хоёр/ төгрөгийн 95 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:", 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.1-д "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш2 үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлсан "ТАБ-аас аудит хийх журам"-ын 19 дүгээр зүйлийн 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11-т "хууль тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь тогтмол байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАГДЖАВ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 25 өдөр Дугаар 1021 /АО111241 Улаанбаатар хот

СНАГ-2025/031-НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дижитал технологийн эрин үед тулгамдсан хүний эрхийн асуудлыг Австрали улс хэрхэн зохицуулж, даван туулж байгаа туршлагыг танин мэдэх, хүний эрхийг хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах зорилготой "Цахим эринд хүний эрхэд суурилсан хөгжлийг дэмжих" хөтөлбөрийн санхүүжилтээс зориулалт зөрчин нэр бүхий их сургуулийн төгсөгчдийн холбооноос эмхэтгэн гаргасан 120 боть номыг худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;", 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна." гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАГДЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ТЭМДЭГЛЭЛ

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг